БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## Баянхонгор сумын 11-р цэцэрлэг 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** БНА-2019/115/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Баянхонгор хот
2018 он


Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат
Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Цэцэгмаа
Утас:70442424 Цахим хаяг: tsetsegmaad@audit.gov.mn
Гэрээт аудитор: Б.Цогзолмаа
Утас: 94640011
Цахим хаяг:ttsogzolmaabaterdene@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт |
| АДБОУС | Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт |
| АОУС | Аудитын олон улсын стандарт |

## АГУУЛГА

1 Аудитын гэрчилгээ ........................................ 3
2 Аудитын тайлан ........................................ 5
2.1 Оршил ........................................ 5
2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага ........................................ 5
2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт ........................................ 6
2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин ........................................ 6
2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ ........................................ 7
2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал ........................................ 8
2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар ........................................ 8
2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн ........................................ 8
2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ........................................ 9
2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга ........................................ 9
2.11 Шилэн дансны мэдээлэл ........................................ 10
2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга ........................................ 10
2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл ........................................ 10
3 Менежментийн захидал ........................................ 10
3.1 (Аудитын чиглэл) ........................................ 11
3.1.1 Илрүүлэлт: ........................................ 11
3.1.2 Эрсдэл: ........................................ 11
3.1.3 Өгсөн зөвлөмж: ........................................ 11
3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: ........................................ 11
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан ........................................ 11
.4.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........................................ 11
4.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........................................ 12
4.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ........................................ 14
4.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........................................ 16
4.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........................................ 16

# 1 Аудитын гэрчилгээ

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
64101 Номгон, Баянхонгор сум
Утас, факс 70-44-25-84
E-mail; bayankhongor@audit.gov.mn

БАЯНХОНГОР СУМЫН 11 ДҮГЭЭР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Б.ПҮРЭВТОГОО ТАНАА

2019.02.25 № 2/60

танай ______________ -ны №______________ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор сумын 11-р цэцэрлэгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Баянхонгор сумын 11-р цэцэрлэгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор сумын 11-р цэцэрлэгийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл,санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

2519102

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

# 2 Аудитын тайлан

## 2.1 Оршил

Баянхонгор сумын 11-р цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Цэцэрлэгийн эрхлэгч Б.Пүрэвтогоод танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэн аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

## 2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор сумын 11-р цэцэрлэгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор сумын 11-р цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.02.18-наас 2019.02.25–ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.02.25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын Гэрээт аудитор Б.Цогзолмаа хариуцаж хэрэгжүүлэв. Баянхонгор сумын 11-р цэцэрлэгийн 2018 оны

санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2019.01.25-ны өдрийн 18 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

## 2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

## 2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Баянхонгор сумын 11-р цэцэрлэгийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Баянхонгор сумын 11-р цэцэрлэг нь Амьдралын зөв дадал хэвшилтэй, оюунлаг сэтгэх чадвартай иргэнийг төлөвшүүлэхэд судалгаанд суурилсан үйлчилгээ үзүүлнэ. Даам бол хүүхдийн хөгжлийн ирээдүй юм гэсэн зорилго тавин ажиллаж байна.

Үйл ажиллагааны чиглэл:

Сургуулийн өмнөх боловсрол олгох үйлчилгээ

Баянхонгор сумын 11-р цэцэрлэгийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Баянхонгор сумын 11-р цэцэрлэгийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд
дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Байхгүй

## 2.5 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН ДОТООД ХЯНАЛТТАЙ ХОЛБООТОЙ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ҮНЭЛГЭЭ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Баянхонгор сумын 11-р цэцэрлэгийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд 46 оноо авсан тул мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Баянхонгор сумын 11-р цэцэрлэгийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “ACOLOUS, PAYRWOLL” программ хангамж ашигладаг байна.

Баянхонгор сумын 11-р цэцэрлэгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

## 2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Баянхонгор сумын 11-р цэцэрлэгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 8 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 8 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## 2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд Баянхонгор сумын 11 дүгээр цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайланд аудит хийж санал дүгнэлт гаргахад шаардлагатай материаллаг байдлын түвшинг урьдчилсан байдлаар тооцохдоо суурь үзүүлэлтийг үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгох нь зохимжтой гэж үзэв.

Гүйцэтгэлийн шатанд шинж чанарын болон орчин нөхцлийн хувьд материаллаг байдал илрээгүй болно. Баянхонгор сумын 11-р цэцэрлэгийн 2018 оны Нийт зардал 852,0 сая төгрөг бөгөөд сонгосон суурь үзүүлэлтийг *2* хувиар тооцож, материаллаг байдлын түвшнийг урьдчилсан байдлаар 17,0 сая төгрөгөөр тогтоож, Маягт № Б201-ээр баримтжуулан баталгаажуулав.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## 2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 8 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 5 асуудлыг алдаа зөрчилтэйд тооцож, 3 асуудлыг алдаа зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 4 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг B30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг B501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

| № | Шийдэл | Тоо | Дүн | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Зөвлөмж өгсөн | 1 | 39.70 | |
| 2 | Төлбөрийн акт тогтоосон | 0 | 0.00 | |
| 3 | Албан шаардлага өгсөн | 0 | 0.00 | |
| 4 | Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн | 0 | 0.00 | |
| 5 | Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн | 0 | 0.00 | |
| | Дүн | 1 | 39.70 | |

## 2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Байхгүй

## 2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Баянхонгор сумын 11-р цэцэрлэгийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 341,6 сая төгрөгийн төсөв батлагджээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 341,5 сая төгрөг буюу 100 хувьтай байна.

### 2.11 Шилэн дансны мэдээлэл

Баянхонгор сумын 11-р цэцэрлэгийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллага нь Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас хийсэн “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудит”-аар Шилэн дансны хуулийн 6.1-д заасан мэдээллийн өөрт хамаарах 25 мэдээллийг хугацаанд нь, 6.4-д заасан мэдээллээс өөрт хамаарах 5,0 сая төгрөгөөс үнийн дүн бүхий орлогын 11 гүйлгээ байгааг хугацаанд тус тус мэдээлж хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

### 2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Зөвлөмж өгөөгүй.

### 2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянхонгор сумын 11-р цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Баянхонгор сумын 11-р цэцэрлэгийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

## 3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг. Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Баянхонгор сумын 11-р цэцэрлэг нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд орших буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг үзүүлэв. Үүнд:

**3.1. Зардлын данстай холбоотой асуудал**

3.1.1. Илрүүлэлт

Няравын тайланг бүрэн гаргаагүй анхан шатны баримтаар БМ-ын журналд шууд бичилт хийсэн зөрчил илэрсэн.

Энэ нь Үнэн зөв байдал, Үнэлгээ гэсэн  батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна НББ-ийн тухай хуулийн 13.4 заалтыг тус тус зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл

Санхүүгийн тайланд зардал буруу илэрхийлэгдэх өглөг авлага бүрэн тусахгүй байх.

3.1.3. Өгсөн зөвлөмж

НББ-ийн тухай хуулийн 13.4 заалт,  Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалаар батлагдсан нягтлан бодох бүртгэлийг хөтлөх

3.1.4. Няравын тайланг дахин гаргаж 2019 оны 01-р улиралд хариу ирүүлэх Алдаа зөрчлийг хүлээн зөвшөөрч байна. Цаашид анхаарч ажиллана.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТЛАГДСАН ТАЙЛАН

## 4.1. САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **41,251,811.50** | **49,361,338.26** |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | 00.00 | 9,000,000.00 |
| **3471** | **Урьдчилгаа тооцоо** | 00.00 | 9,000,000.00 |
| 34712 | Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа | 00.00 | 9,000,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 41,251,811.50 | 40,361,338.26 |
| **351** | **Түүхий эд материал** | 8,952,957.98 | 9,138,344.74 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 8,952,957.98 | 9,138,344.74 |
| **354** | **Хангамжийн материал** | 32,298,853.52 | 31,222,993.52 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 146,500.00 | 70,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 23,100.00 | 00.00 |
| 35460 | Хүнсний материал | 1,633,585.02 | 706,050.02 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 30,495,668.50 | 30,446,943.50 |
| 2 | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,231,343,616.22** | **796,986,002.16** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,231,343,616.22 | 796,986,002.16 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,231,163,949.40 | 739,476,335.30 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,273,253,900.00 | 722,118,262.98 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -72,504,735.79 | 00.00 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 37,747,264.85 | 36,964,991.85 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -21,651,329.40 | -26,733,384.81 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 39,628,151.22 | 39,543,514.92 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -29,701,585.34 | -35,469,177.12 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 8,249,740.00 | 7,888,740.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -3,857,456.14 | -4,836,612.52 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 179,666.82 | 57,509,666.86 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 770,000.00 | 58,254,000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | -590,333.18 | -744,333.14 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,272,595,427.72** | **846,347,340.42** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,272,595,427.72** | **846,347,340.42** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,272,595,427.72 | 846,347,340.42 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,289,298,150.50 | 1,346,782,150.50 |
| 51101 | Өмч: - төрийн | 1,289,298,150.50 | 1,346,782,150.50 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -16,702,722.78 | -500,434,810.08 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -16,702,722.78 | -16,702,722.78 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -483,732,087.30 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,272,595,427.72** | **846,347,340.42** |

## 4.2. САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **322,805,851.00** | **359,317,245.98** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,330,848.00** | **11,302,278.98** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 1,330,848.00 | 11,302,278.98 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 1,330,848.00 | 11,302,278.98 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 890,848.00 | 00.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 440,000.00 | 11,302,278.98 |

| | | | |
|---|---|---|---|
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,421,103.00** | **6,411,467.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 319,053,900.00 | 341,603,500.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 00.00 | 2,044,300.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 2,044,300.00 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | 1,481,740.00 | 00.00 |
| 133003 | Хөрөнгийн | 1,481,740.00 | 00.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 939,363.00 | 4,367,167.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 939,363.00 | 4,367,167.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **345,343,324.71** | **372,851,916.16** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **345,343,324.71** | **372,851,916.16** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 338,728,357.71 | 361,529,767.16 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 174,736,688.00 | 182,009,918.00 |
| 210101 | Үндсэн цалин | 137,713,359.00 | 163,223,218.00 |
| 210102 | Нэмэгдэл | 00.00 | 7,568,300.00 |
| 210104 | Урамшуулал | 37,023,329.00 | 11,218,400.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 20,179,908.00 | 21,544,600.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 20,179,908.00 | 21,544,600.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 48,233,600.00 | 57,871,800.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,767,100.00 | 4,002,100.00 |
| 210302 | Түлш, халаалт | 32,082,500.00 | 36,665,700.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 12,384,000.00 | 17,204,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 2,471,160.00 | 2,713,700.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 586,860.00 | 536,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 290,000.00 | 290,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 648,300.00 | 899,019.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 82,500.00 | 86,700.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 655,700.00 | 901,581.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 207,800.00 | 00.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 55,452,585.00 | 59,037,035.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 158,800.00 | 77,300.00 |
| 210502 | Хоол, хүнс | 55,293,785.00 | 58,217,035.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 00.00 | 742,700.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 252,900.00 | 254,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 252,900.00 | 254,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 153,900.00 | 00.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 153,900.00 | 00.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,554,648.00 | 1,489,500.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 663,800.00 | 1,489,500.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 890,848.00 | 00.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 35,692,968.71 | 36,609,214.16 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 943,000.00 | 1,806,300.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 60,500.00 | 138,100.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 34,689,468.71 | 34,664,814.16 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 6,614,967.00 | 11,322,149.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 6,604,263.00 | 11,207,467.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 939,363.00 | 4,367,167.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 00.00 | 6,474,600.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,664,900.00 | 365,700.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 10,704.00 | 114,682.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 10,704.00 | 114,682.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-22,537,473.71** | **-13,534,670.18** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 1,242,850.00 | 470,197,417.12 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 00.00 | 146,796.95 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 1,242,850.00 | 1,338,338.24 |
| 225007 | Хөрөнгийн дахин үнэлгээний зардал | 00.00 | 468,712,281.93 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | -1,242,850.00 | -470,197,417.12 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-23,780,323.71** | **-483,732,087.30** |

## 4.3. МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **320,884,111.00** | **348,014,967.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **890,848.00** | **00.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 890,848.00 | 00.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 890,848.00 | 00.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 890,848.00 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **319,993,263.00** | **348,014,967.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 319,053,900.00 | 341,603,500.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 00.00 | 2,044,300.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 2,044,300.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 939,363.00 | 4,367,167.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 939,363.00 | 4,367,167.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **320,884,111.00** | **348,014,967.00** |

| | | | |
|---|---|---|---|
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **320,884,111.00** | **348,014,967.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **314,269,144.00** | **336,692,818.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 175,283,196.00 | 182,009,918.00 |
| 210101 | Үндсэн цалин | 154,306,396.00 | 163,398,518.00 |
| 210102 | Нэмэгдэл | 7,568,300.00 | 7,568,300.00 |
| 210104 | Урамшуулал | 13,408,500.00 | 11,043,100.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 19,383,400.00 | 21,544,600.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 19,383,400.00 | 15,135,833.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 00.00 | 1,663,900.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 00.00 | 1,331,100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 00.00 | 332,700.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 00.00 | 3,081,067.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 48,233,600.00 | 57,871,800.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,767,100.00 | 4,002,100.00 |
| 210302 | Түлш, халаалт | 32,082,500.00 | 36,665,700.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 12,384,000.00 | 17,204,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 2,372,100.00 | 2,475,100.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 464,700.00 | 320,900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 290,000.00 | 290,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 648,300.00 | 899,019.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 82,500.00 | 86,700.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 886,600.00 | 878,481.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 56,279,400.00 | 59,584,500.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 77,000.00 | 77,300.00 |
| 210502 | Хоол, хүнс | 56,202,400.00 | 57,289,500.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 00.00 | 2,217,700.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 9,752,900.00 | 9,254,000.00 |
| 210602 | Тавилга | 9,500,000.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 252,900.00 | 9,254,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 153,900.00 | 00.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 153,900.00 | 00.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,554,648.00 | 1,489,500.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 663,800.00 | 1,489,500.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 890,848.00 | 00.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,256,000.00 | 2,463,400.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,113,300.00 | 2,325,300.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 142,700.00 | 138,100.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **6,614,967.00** | **11,322,149.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 6,604,263.00 | 11,207,467.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 939,363.00 | 4,367,167.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 00.00 | 6,474,600.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,664,900.00 | 365,700.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 10,704.00 | 114,682.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 10,704.00 | 114,682.00 |

## 4.4.ЦЭВЭР ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 1,289,298,150.50 | 00.00 | 33,157,134.72 | 00.00 | 1,322,455,285.22 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,289,298,150.50** | **00.00** | **33,157,134.72** | **00.00** | 1,322,455,285.22 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -5,216,133.11 | 00.00 | -5,216,133.11 |
| C08 | **2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,289,298,150.50** | **00.00** | **-16,702,722.78** | **00.00** | 1,272,595,427.72 |
| D01 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,289,298,150.50** | **00.00** | **-16,702,722.78** | **00.00** | 1,272,595,427.72 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,289,298,150.50** | **00.00** | **-16,702,722.78** | **00.00** | 1,272,595,427.72 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 57,484,000.00 | 00.00 | -483,732,087.30 | 00.00 | -426,248,087.30 |
| D09 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,346,782,150.50** | **00.00** | **-500,434,810.08** | **00.00** | 846,347,340.42 |

## 4.5. ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 319,053,900.00 | 319,043,196.00 | 341,603,500.00 | 341,488,818.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 319,053,900.00 | 319,043,196.00 | 341,603,500.00 | 341,488,818.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 313,389,000.00 | 313,378,296.00 | 334,763,200.00 | 334,648,518.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 175,293,900.00 | 175,283,196.00 | 180,080,300.00 | 179,965,618.00 |
| 210101 | Үндсэн цалин | 154,317,100.00 | 154,306,396.00 | 161,293,600.00 | 161,354,218.00 |
| 210102 | Нэмэгдэл | 7,568,300.00 | 7,563,800.00 | 7,568,300.00 | 7,568,300.00 |
| 210104 | Урамшуулал | 13,408,500.00 | 13,408,500.00 | 11,218,400.00 | 11,043,100.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 19,393,400.00 | 19,383,400.00 | 21,544,600.00 | 21,544,600.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 12,426,700.00 | 19,393,400.00 | 14,711,600.00 | 15,135,833.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,391,400.00 | 00.00 | 1,708,200.00 | 1,663,900.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,739,100.00 | 00.00 | 1,366,600.00 | 1,331,100.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 347,800.00 | 00.00 | 341,600.00 | 332,700.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,478,400.00 | 00.00 | 3,416,600.00 | 3,081,067.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 48,233,600.00 | 48,233,600.00 | 57,871,800.00 | 57,871,800.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,767,100.00 | 3,767,100.00 | 3,552,100.00 | 4,002,100.00 |
| 210302 | Түлш, халаалт | 32,082,500.00 | 32,082,500.00 | 37,115,700.00 | 36,665,700.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 12,384,000.00 | 12,384,000.00 | 17,204,000.00 | 17,204,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 2,372,100.00 | 2,372,100.00 | 2,475,100.00 | 2,475,100.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 464,700.00 | 464,700.00 | 149,100.00 | 320,900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 290,000.00 | 290,000.00 | 290,000.00 | 290,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 648,300.00 | 648,300.00 | 1,210,500.00 | 899,019.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 82,500.00 | 82,500.00 | 82,800.00 | 86,700.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 886,600.00 | 886,600.00 | 742,700.00 | 878,481.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 56,279,400.00 | 56,279,400.00 | 59,584,500.00 | 59,584,500.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 77,000.00 | 77,000.00 | 77,300.00 | 77,300.00 |
| 210502 | Хоол, хүнс | 56,202,400.00 | 56,202,400.00 | 57,289,500.00 | 57,289,500.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 00.00 | 00.00 | 2,217,700.00 | 2,217,700.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 9,752,900.00 | 9,752,900.00 | 9,254,000.00 | 9,254,000.00 |
| 210602 | Тавилга | 9,500,000.00 | 9,500,000.00 | 00.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 252,900.00 | 252,900.00 | 9,254,000.00 | 9,254,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 153,900.00 | 153,900.00 | 00.00 | 00.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 663,800.00 | 663,800.00 | 1,489,500.00 | 1,489,500.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 663,800.00 | 663,800.00 | 1,489,500.00 | 1,489,500.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1256000.00 | 1256000.00 | 2463400.00 | 2463400.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,113,300.00 | 1,113,300.00 | 2,325,300.00 | 2,325,300.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 142,700.00 | 142,700.00 | 138,100.00 | 138,100.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 5664900.00 | 5664900.00 | 6840300.00 | 6840300.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 00.00 | 00.00 | 6,840,300.00 | 6,840,300.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 00.00 | 00.00 | 6,474,600.00 | 6,474,600.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,664,900.00 | 5,664,900.00 | 365,700.00 | 365,700.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 319,053,900.00 | 319,043,196.00 | 343,647,800.00 | 341,488,818.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 319,053,900.00 | 319,043,196.00 | 343,647,800.00 | 341,488,818.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 319,053,900.00 | 319,053,900.00 | 343,647,800.00 | 341,488,818.00 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 01.00 | 01.00 | 01.00 | 01.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 01.00 | 01.00 | 01.00 | 01.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 25.00 | 25.00 | 25.00 | 25.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 | 01.00 | 01.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 15.00 | 15.00 | 15.00 | 15.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 09.00 | 09.00 | 09.00 | 09.00 |
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | 240.00 | 210.00 | 185.00 | 185.00 |
| **631** | **СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА** | 240.00 | 205.00 | 185.00 | 185.00 |
| 631001 | Төрийн өмчит СӨБ байгууллага | 240.00 | 205.00 | 185.00 | 185.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **25.00** | **25.00** | **25.00** | **25.00** |
| 650004 | СЄБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 15.00 | 15.00 | 15.00 | 15.00 |
| 650009 | Тєрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 10.00 | 10.00 | 10.00 | 10.00 |